

38 15



**НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР, СПОРТЫН
ХОРООНЫ ДАРГЫН ТУШААЛ**

2009 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

**“ЭРҮҮЛ ОРЧИН-ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН
ХЭВ МАЯГ” СЭДЭВТ СУРГАЛТ СЕМИНАР
ЗОХИОН ЯВУУЛАХ ТУХАЙ**

Монголд Улсын “Биеийн тамир, спортын тухай” хууль, “Халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах Үндэсний хөтөлбөр” батлах тухай Засгийн газрын 2005 оны 246 дугаар тогтоол, “Биеийн тамир, спортын хамтлаг байгуулах тухай” Нийслэлийн Засаг даргын 2006 оны 165 дугаар захирамжийг тус тус хэрэгжүүлэх зорилгоор **ТУШААХ НЬ:**

Нэг. Нийслэл, дүүргийн төр, захиргааны байгууллага, харьяа газар, агентлаг, аж ахуйн нэгж, цэцэрлэг, Ерөнхий боловсрол, их, дээд сургуулиудад биеийн тамир, спортын хамтлагийн дарга, арга зүйчдийн “Эрүүл орчин – Эрүүл амьдралын хэв маяг” сэдэвт сургалт, семинарыг 2009 оны 03 дугаар сарын 20-ны өдөр Улаанбаатар хотноо зохион байгуулсугай.

Хоёр. Сургалт, семинарын төсөв, хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

Гурав. Сургалт, семинарт шаардагдах 170.000 /нэг зуун далан мянга/ төгрөгийг сургалт, семинар, зөвлөгөөний зардлаас гаргахыг ня-бо /Ж.Цэдэнсодном/-д зөвшөөрсүгэй.

Дөрөв. Сургалт, семинарыг зохион байгуулалтын өндөр түвшинд явуулахыг ахлах мэргэжилтэн /А.Болдмаа/-д даалгасугай.



Ж.ГАНБОЛД

injunction-2009

050029

39 30

НБТСГ-ын даргын 2009 оны 03 дугаар сарын
13-ны өдрийн 14 дугаар тушаалын нэгдүгээр
хавсралт



**“ЭРҮҮЛ ОРЧИН–ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ”
СЭДЭВТ СУРГАЛТ СЕМИНАР ЗОХИОН
ЯВУУЛАХ ТӨСӨВ**

№	Зардлын нэр	Дүн /төг/
1.	Багшийн хөлс: /8 цаг х 10000 төг/	80.000
2.	Заал, талбайн хөлс:	30.000
3.	Бичиг хэргийн зардал:	20.000
4.	Гарын авлага, сурталчилгаа	40.000
НИЙТ ДҮН:		170.000

40 31

НБТСГ-ын даргын 2009 оны 13-ны өдрийн 14 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



**“ЭРҮҮЛ ОРЧИН-ЭРҮҮЛ АМЬДРАЛЫН ХЭВ МАЯГ”
СЭДЭВТ СУРГАЛТ, СЕМИНАРЫН БАГШ НАРЫН
БҮРЭЛДЭХҮҮН**

№	Багш нарын нэр	Албан тушаал
1.	О.Болор-Эрдэнэ	Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын мэргэжилтэн
2.	Б.Сонинхүү	Нийслэлийн Эрүүл мэндийн газрын мэргэжилтэн
3.	Ж.Баасансүрэн	Засгийн газрын хэрэгжүүлэгч Агентлаг Биеийн тамир, спортын газрын мэргэжилтэн
4.	Б.Эрдэнэбат	Нийслэлийн Захирагчийн Ажлын албаны Биеийн тамир, спортын хамтлагийн дарга
5.	Б.Жияандорж	Монголын Адал явдалт спорт аялалын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга



БАТЛАВ:
НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА

Ж.ГАНБОЛД

**ХАМТЛАГИЙН АРГА ЗҮЙЧДИЙН СУРГАЛТ
СЕМИНАРИЙН ХӨТӨЛБӨР**

2008-03-13

Гаряг Цаг	03-р сарын 20
09.00-09.40	Хамтлагуудын мөрдөх хууль эрх зүйн баримт бичгүүд, хамтлагуудад зайлшгүй хэвшүүлэх ажил, дотоод зохион байгуулалтын талаар О.Болор-Эрдэнэ /НБТСГ-ын мэргэжилтэн/
09.40-11.10	ХБӨ-ны талаархи орчин үеийн ойлголт, чиг хандлага Б.Сонинхүү /НЭМГ-ын мэргэжилтэн/
11.20-12.50	Хүн амын бие бялдрын түвшин тогтоох сорил авах аргачлал Ж.Баасансүрэн /ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг БТСГ газрын мэргэжилтэн/
13.00 -14.00	Үдийн завсарлага
14.00-15.30	Нийслэлийн хэмжээнд ХБӨ-өөс сэргийлэх, хянах үндэсний болон дэд хөтөлбөрийн 2008 оны тайланд хийсэн үнэлгээ Б.Сонинхүү /НЭМГ-ын мэргэжилтэн/
15.40-17.10	Нийслэлийн 2007, 2008 оны шилдэг хамтлаг Нийслэлийн Захирагчийн ажлын албаны үйл ажиллагааг таницуулах, туршлага судлах Б.Эрдэнэбат /НЗАА-ны биеийн тамир, спортын хамтлагийн дарга/
17.10-18.00	Нийтийн бүжгийн талаархи ойлголт Б.Жияандорж

**НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР,
СПОРТЫН ГАЗАР**